


Шүүх шинжилгээний ерөнхий газрын  
2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн

04/11460 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт



ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ГАЗАР

2025 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Г.Эрдэнэбулганы 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 4/2315 тоот “Биелэлт ирүүлэх тухай” албан бичгийн дагуу УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, УИХ-ын 2020 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний тайлан, ажлын үр дүнг үнэллээ.

Үнэлгээг удирдлагаас өгсөн үүргийн дагуу тус Аюулгүй байдал, дотоод хяналт, аудитын газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Т.Буяндэлгэр, цагдаагийн хошууч Т.Нүрмаа, мэргэжилтэн, Эрдэм шинжилгээ, сургалт хөгжүүлэлтийн төвийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Э.Ижилцэцэг нар хяналт-шинжилгээ хийж, үнэллээ.

1. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилт Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан, тогтоолын 3-р хавсралт “Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д тус арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тусгайгүй байна.

Биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Заалтын тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					Дундаж хувь
				х/б	0-29	30-59	60-84	85-с дээш	
1	7.4 Хууль сахиулах салбарын хууль эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ.	7.4.3. Шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлнэ.	1	-	-	-	-	1	100
Нийт			1	-	-	-	-	1	100

(Биелэлтийг хавсралтаас үзнэ үү)

2. Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах ажил, арга хэмжээний биелэлт

Тус хөтөлбөрт байгууллагын чадавхыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Мон-22 төслийг БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангийн хөнгөлөлттэй зээл хөрөнгөөр санхүүжүүлнэ гэж тусгасан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаалаар нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн “Удирдах хороо”-г, мөн Сайдын 2025 оны А/101 дүгээр тушаалаар “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг тус тус байгуулсан байна.

Төслийн хүрээнд барилга байгууламжийн зураг, төсвийг боловсруулж, батлуулсан байна. Хууль зүй, дотоод хэргийн яам 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр төслийн зөвлөхтэй байгуулсан гэрээнд төслийн хэрэгжүүлэх хугацаанд 80 алба хаагчийг БНСУ-ын Сөүлийн үндэсний их сургуульд чадавхжуулах сургалтад хамруулахаар тусгаснаас 2025 оны байдлаар 40-н алба хаагчийг хамруулсан байна.

Сангийн сайдын 01/10803 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу 2025 оны санхүүжилтийг түр хойшлуулсан байна. Сангийн яам болон БНСУ-ын Экзим банкнаас төслийн ач холбогдол, хүрэх үр дүнг харгалзан үзэж, хэрэгжилтийг хугацааг 2027 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.6. “Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шинэ төрлийн шинжилгээний чанар, үр дүнг олон улсын жишигт хүргэж, шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.” гэсэн зорилтын хүрээнд “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22” төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг 2025 онд 30 хувьтай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, төсөл хэрэгжих хугацаа сунгасан тул 2025 оны биелэлтийг гүйцэтгэлд тулгуурлан 92 хувиар үнэллээ.

## 2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнөөс Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах ажил, арга хэмжээний хэрэгжилт

Биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Хөтөлбөрийн үр дүн	Зорилт хэрэгжүүлэх арга хэмжээ	Заалтын тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь				
				х/б	0-29	30-59	60-84	85-с дээш
1	4.2.1. Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ.	4.2.1.2. Шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлэх;	1	-	-	-	-	1
2	4.2.2. Шүүх шинжилгээний чадавхыг бэхжүүлнэ.	4.2.2.1. Шүүх шинжилгээний байгууллагын шинжилгээний техник, тоног төхөөрөмжийг сайжруулах;	1	-	-	-	-	1
			1	-	-	-	-	1
<b>Нийт дүн (хүрэх түвшин, шалгүүр үзүүлэлт)</b>			<b>3</b>	-	-	-	-	<b>100</b>

(Төлөвлөгөөний биелэлтийг хавсралтаас үзнэ үү).

Төлөвлөгөөний 4.2.1.2. Шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлэх зорилтын хүрээнд МОН-22 төслийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтэд Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах арга хэмжээний хүрэх түвшинг 3 шалгуур үзүүлэлтээр дүгнэхээр баталсан. Үүнд:

1. Иргэдээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой гаргасан гомдлын зорилтод түвшинг 17 гэж төлөвлөснөөс хүрсэн түвшин 12 болж буурсан байна;
2. Давтан шинжилгээний зорилтод түвшинг 800 гэж төлөвлөснөөс хүрсэн түвшин 783 болж буурсан байна;
3. Шүүх шинжилгээний байгууллагын албадын хүчин чадлыг нэмэгдүүлсэн байдлын зорилтод түвшинг 10 гэж төлөвлөснөөс хүрсэн түвшин 10 байна. (Тайланг хавсралтаас харна уу).

### **ДҮГНЭЛТ, САНАЛ**

1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2025 оны хэрэгжилт 100 хувь буюу үр дүнтэй.

Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22” төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг 2025 оны ажлын гүйцэтгэлээр 92 хувь буюу үр дүнтэй.

2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнөөс Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах ажил, арга хэмжээний хэрэгжилт 100 хувь буюу үр дүн гарсан гэж үнэллээ.

Цаашид МОН-22 төслийн хүрээнд хийгдэж байгаа барилга байгууламжийн орц гарц, гүүрэн байгууламж барихад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа саналыг тус тус илтгэн танилцуулж байна.

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС**  
**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД ХАМААРАХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**  
**(2025 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Төсөл арга, хэмжээ	Шалгуур үзүүлэлт / Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт		Зарцуулсан төсөв (сая.төг)	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь	Хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар
			Суурь түвшин (2023он)	Зорилтот түвшин (2025 он)	Санхүүжилт (сая.төг)	Эх үүсвэрийн ангилал			
<b>ТӨРӨВ, ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>									
<p><b>ТЕЗ-ийн үр дүн. 4.2. Шүүхэд итгэлийг нэмэгдүүлнэ.</b>  <b>Хөтөлбөрийн үр дүн. 4.2.1. Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлнэ.</b>  <b>Бодлогын үндэслэл: МУХТЖҮЧ- 7.4.3, ЗГҮАХ- 4.1.5.6</b></p>									
1	4.2.1.2. Шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлэх;	Хэрэгжүүлэх төсөл / тоо	0	1	15,000.0	Гадаад зээл	3,361.44	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаалаар нэгдсэн төсөл хэрэгжүүлэх зэрэгжүүлэх нэгжийн "Удирдах хороо"-г, мөн Сайдын 2025 оны А/101 дүгээр тушаалаар "Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийг тус тус байгуулсан. Сангийн сайдын 2025 оны 71 дүгээр тушаалаар төсөл хэрэгжүүлэх зэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог баталсны дагуу ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/81 дугаар тушаалаар "Ажлын байрны тодорхойлолт"-ыг баталж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 2025.06.23-ны өдрөөс "Төсөл хэрэгжүүлэх нэгж" төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.	МУ-ын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд хэлэлцээрийг 2021 онд байгуулж, 2023 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Зээлийн хэлэлцээрт МУ-ын Засгийн газар нь барилга барих газар, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхээр заасан бөгөөд үерийн далан, дэд бүтцийн ажлуудтай холбоотойгоор зарим ажлууд хойшлогдож, барилгын зураг, төсвийн ажил үүнтэй уялдан удааширсан нь төслийн хэрэгжилтэд нөлөөлж байна. Төслийн хэрэгжилт 2025 оны 07 дугаар сарын 03-ны дуусгавар болохоор төлөвлөж, байсан хэдий ч төсөл хугацаандаа эхлээгүй,

							<p>үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.</p> <p>ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/82 дугаар тушаалаар “Үнэлгээний хороо”-г байгуулсан.</p> <p>Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр БНСУ-ын “Аум энд Ли Архитектур энд Ассоциаци” ХХК сонгон шалгарч, 2023.06.26-ны өдрөөс гэрээ байгуулсан бөгөөд 2023 оны 8 дугаар сард үнийн дүнгийн 20 хувь буюу 2,281,775,238.0 төгрөг, 2025 оны 8 дугаар сард үнийн дүнгийн 30 хувь буюу <b>3,361,442,370.0</b> төгрөгийг тус тус шилжүүлсэн.</p> <p>Төслийн хүрээнд БНСУ-ын Сеулийн үндэсний их сургуульд 2024 онд 1-р ээлж, 2025 онд 2, 3, 4-р ээлжийн сургалтад нийт 40 шинжээч эмчийг хамруулж, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлээд байна.</p> <p>Барилгын хөгжлийн төвөөс ажлын зураг, төсвийг баталж, 2025 оны 384/2025 дугаар “Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлтийн нэгтгэл”-ийг ирүүлсэн.</p> <p>Төв замаас төсөл хэрэгжих талбай хүртэлх 1300 метр авто зам, байгууламж төлөвлөх</p>	<p>дэд бүтэц, тендерийн сонгон шалгаруулалт, Сангийн яамнаас хэрэгжилтийг түр зогсоосонтой холбоотойгоор хэрэгжилтийн хугацаа удааширч, хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон.</p> <p>Сангийн сайдын 2024 оны 01/1803 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр тус төслийг “2025 онд санхүүжүүлэх боломжгүй, түр хойшлуулсан” гэж мэдэгдсэн хэдий ч Сангийн яам болон БНСУ-ын Экзим банкаас төслийн ач холбогдол, хүрэх үр дүнг харгалзан үзэж, хэрэгжилтийг хугацааг 2027 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгаж, төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх “Төсөл хэрэгжүүлэх нэгж”-ийг байгуулсан.</p> <p>Төслийн явц, хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг төслийн нэгжээс дараах байдлаар тусгах санал өгсөн. Үүнд: 1.Олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон лабораторийн иж бүрэн цогцолбор барилга байгууламж байгуулагдсан байх, 2.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдэж, суурилуулагдсан байх, 3.Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байх.</p>
--	--	--	--	--	--	--	--	---

	<p>МЗХ2024/00-836 дугаартай даалгаврыг батлуулсан.</p> <p>МУ-ын Засгийн газрын хариуцах дэд бүтцийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд төслийн талбайд инженер геологийн судалгаа, үерийн хамгаалалтын далан сувгийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн /зураг/.</p> <p>Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр зарласан НХААГ/20250101028 дугаартай "Шүүх шинжилгээний ерөнхий газар"-ын үйлчилгээ, контор, шинжилгээний барилга орц, гарцын гүүрэн байгууламжийн (Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 21 дүгээр хороо) тендерийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан боловч Сангийн сайдын 2024 оны 01/10803 дугаартай албан бичиг, 2025 оны нийслэлийн төсвийн тодотголоор уг төсөв хасагдсан байна.</p> <p>Иймд төслийн хэрэгжилтийн хугацаа 2027 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс хойш дахин сунгагдахгүй нөхцөлтэй тул барилга угсралтын ажлыг 2026 оны эхний улиралд багтаан эхлүүлж, тухайн онд ашиглалтад өгөхөөр төлөвлөж байгаатай холбоотойгоор барилга байгууламжийн орц</p>	<p>Дээрх 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2023 онд зээлийн хэлэлцээрт заасны дагуу төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх 1 зөвлөх үйлчилгээг авч, төслийн нэгжийг байгуулан, холбогдох зөвшөөрлийг авч, 2024, 2025 онд 4 ээлжийн сургалтаар нийт 40 алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулж, алба хаагчдыг чадавхжуулсан зэрэг ажил, арга хэмжээний гүйцэтгэлийг харгалзан үзэж 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар хэрэгжилт 33 хувьтай байна.</p> <p>Зөвлөх үйлчилгээний нийт төлбөр нь төслийн нийт хөрөнгө оруулалтын 20.6 хувийг эзлэх бөгөөд тайлант хугацаанд 2 удаагийн гүйлгээгээр зөвлөх үйлчилгээний 50 хувь буюу нийт хөрөнгө оруулалтын 10.3 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилтийг олгоод байна.</p> <p>Цаашид хэрэгжүүлэх ажил, хүлээгдэж буй үр дүн: барилга байгууламжийн орц гарц, гүүрэн байгууламж барихад шаардлагатай санхүүжилтийг шийдэрлүүлснээр барилгын ажлыг эхлүүлж, төслийг хугацаанд нь амжилттай хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p>
--	---	---

									гарц, гүүрэн байгууламж барихад шаардлагатай хөрөнгийг Нийслэлийн 2026 оны төсвийн төсөлд тусгаж өгөх талаарх хүсэлтийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 2025 оны 1/1415 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлэн ажиллаад байна. Үнэлгээ 100 хувь.	
<b>Хөтөлбөрийн үр дүн. 4.2.2. Шүүх шинжилгээний чадавхыг бэхжүүлнэ.</b> <b>Бодлогын үндэслэл: МУХТЖҮЧ-5.5.4, ЗГҮАХ-4.1.5.6</b>										
2	4.2.2.1. Шүүх шинжилгээний байгууллагын шинжилгээний техник, тоног төхөөрөмжийг сайжруулах;	Сайжруулалт хийх 7гоо (хими, гарын мөр, гэрэл зураг боловсруулах лаборатори)	0	3	3,130.4	Улсын төсөв	1,986.4		<b>Гарын мөрийн шинжилгээний лабораторид:</b> Тус газрын 2025 оны хөрөнгө оруулалтын зардлаас "Гарын хээний адилтгалын шинжилгээний төв сервер, ажлын станц, тоног төхөөрөмж"-д "Ньюкомпас" ХХК-тай 1,550.1 сая төгрөгийн гэрээ байгуулж, ОХУ-ын Челябинск мужийн Миас хотын "Папилон компани"-ийн мэргэжилтнүүд 2025 оны 07-р сард Гарын мөрийн шинжилгээний лабораторид гарын мөрийн автомат харьцуулалтын сүүлийн хувилбар болох "Адис-Папилон 9" системийн программ хангамж, төв сервер, ажлын станц болон бусад тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, шинэчлэлт хийхийн зэрэгцээ 14 криминалистикийн шинжээчийг ОХУ-д практик сургалтад хамруулж, алба хаагчдыг чадавхжуулсан. Үүний үр дүнд гарын хээний нэгдсэн сангийн	<b>Гэрэл зураг боловсруулах лаборатори:</b> -"Гэрэл зураг боловсруулах машин" худалдан авах 444.0 сая төгрөгийн гэрээг "Хасу бизнес групп" ХХК-тай байгуулсан боловч гэрээний хугацаанд барааг нийлүүлээгүй тул гэрээний хэрэгжилтийг хангуулахаар албан бичиг хүргүүлж, утсаар мэдэгдэж, удирдлагуудтай нь уулзалт хийсэн боловч гэрээний үүргээ биелүүлээгүй тул тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулахаар Худалдан авах ажиллагааны газарт 2025.11.10-ны өдрийн 03/11227 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлж, 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр дахин цахим системд нийтэлсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 09-ны өдөр үнэлгээний хороо хуралдаж, шийдвэр гарахыг хүлээж байна.

хүчин чадал нэмэгдэж, гарын мөр, дардас, хүний дүр төрх болон бусад мэдээллийг цахимаар бүртгэх, харьцуулан шинжлэх арга, аргачлал сайжирсан.

**Химийн шинжилгээний**

**лабораторид:** Тус газрын 2025 оны урсгал зардлаас "Мед импекс" ХХК-тай гэрээ байгуулан "Agilent брендийн "FTIR 5500" маркийн Үл мэдэгдэх бодис тодорхойлох **156.8** сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авсан. Мөн шинжилгээний урвалж бодис худалдан авах гэрээг "Сетунари" ХХК-тай **202.3** сая төгрөг, шинжилгээний хий худалдан авах гэрээг "Глобал Ацетилен" ХХК-тай **55.6** сая төгрөг, шинжилгээний стандарт бодис болон кит худалдан авах гэрээг "Грийнхимистри" ХХК-тай **21.6** сая төгрөгөөр тус тус байгуулан тогтмол нийлүүлэн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

**Гэрэл зураг боловсруулах**

**лабораторид:** гэрэл зураг боловсруулах цаас худалдан авахаар **55.0** сая төгрөгийн тендер шалгаруулалтыг зарлан 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нээж, 2 оролцогч оролцож, "Иzzi оффис" ХХК-тай 54.4 сая төгрөгийн гэрээг байгуулан ажиллаж байна. Үнэлгээ 100 хувь.



урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр хүрээлэн буй орчны шинжилгээ үнэлгээ хийхэд шаардлагатай (клинометр, зай хэмжигч, модны хөрөө, хий тодорхойлогч багаж, байршил тогтоогч, хөрсний температур хэмжигч зэрэг) нийт 12 төрлийн багаж хэрэгслийг худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. **(Зарцуулсан төсөв 19.9 сая төгрөг).**

Ховд аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв нь тус Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр хэргийн газрын үзлэг, шинжилгээний гэрэл зургийн чанар, үр дүнг дээшлүүлэхэд шаардлагатай олон үйлдэлт лазер принтерийг худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. **(Зарцуулсан төсөв 7.0 сая төгрөг).**

Өвөрхангай аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвд тус аймгийн болон Хархорин сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр албаны хэрэгцээнд ашиглагдах техник, хэрэгслийг шийдвэрлэсэн. **(Зарцуулсан төсөв 4.9 сая төгрөг).**

Үнэлгээ 100 хувь.

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛТ ТУСГАГДСАН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД ХАМААРАХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хэсрэлт

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжи х хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2025 оны зорилтот түвшин, үр дүнийн үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь
18	7.4. Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ.	7.4.3. Шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлнэ	2021 - 2025			100%
<p><b>7. ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ</b></p> <p><b>Бие даасан, хараат бус байдлыг хангах чиглэлээр:</b></p> <p>"Шүүх шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт, ерөнхий шавардлага MNS 7078:2025" үндэсний стандартыг батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. (Холбоос линк: <a href="https://nfa.gov.mn/uploads/files/standart_darga20251113170518.pdf">https://nfa.gov.mn/uploads/files/standart_darga20251113170518.pdf</a>)</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны цахим системийн (<a href="https://forensic.nfa.gov.mn/">https://forensic.nfa.gov.mn/</a>) шинжилгээний бүртгэлийн модуль болон шинжилгээг төрөл тус бүрээр урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах системийн хөгжүүлэлтийг хийж 2025.01.06-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлж, шинжилгээг цахимаар хуваариалан ажиллаж байна.</p> <p>Байгууллагын үйл ажиллагаанд 2024 онд нэвтрүүлсэн "Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015" стандартын "Магадлах-1" аудитад амжилттай хамрагдаж, "Монсерфт" ХХК-нэс гэрчилгээг хадгалахаар шийдвэрлэсэн. Мөн 2025 онд УИТ-өөс 12 шинжилгээний лабораторид ISO/IEC 17025:2017 (ISO/IEC 17025:2018) стандартын "Итгэмжлэлийн гэрчилгээ" олгосноор шинжилгээний үр дүн Ази, Номхон далайн бүсийн болон "ILAC" ОУ-ын байгууллагын 156 гишүүн оронд хүлээн зөвшөөрөгдөх болсон. (Холбоос линк: <a href="https://nfa.gov.mn/site/status_page/510">https://nfa.gov.mn/site/status_page/510</a>)</p> <p>Байгууллагын үйл ажиллагаанд "ISO/IEC 27001:2022 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо" стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд "Систем центр" ХХК-нэс зөвлөх үйлчилгээ авч, зөрүүний шинжилгээ, эрсдлийн үнэлгээ, мэдээллийн хөрөнгийн бүртгэл хийж, холбогдох 6 журмыг баталж ажилласан.</p> <p>Америкийн Нэгдсэн Улсын Ойн албаны төслийн хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 04, 05-ны өдрүүдэд "Society for Wildlife Forensic Science" байгууллагын "Зэрлэг амьтан, ургамлын шүүх шинжилгээний стандарт ба улирдаж (SWFS)"-ийн дагуу митохондрийн ДНХ-ийн шинжилгээний лаборатори, хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээний лаборатори үнэлгээтэй хамрагдсан. (Холбоос линк: <a href="https://nfa.gov.mn/site/single/425">https://nfa.gov.mn/site/single/425</a>)</p> <p><b>Чадавхыг дээшлүүлэх чиглэлээр:</b></p> <p>АНУ-ын "Collaborative Testing Services"-ийн сорилтод ДНХ, Хими, Митохондрийн ДНХ, Цахим технологийн шинжилгээний лабораториуд 2025 онд оролцож, шинжилгээний үр дүнг олон улсаар баталгаажуулсан бөгөөд Олон улсын "ISO/IEC 17043" стандартаар магадлан итгэмжлэгдсэн БНСУ-ын Үндэсний цагдаагийн газраас зохион байгуулдаг "KOLAS" үр чадвараа олон улсаар баталгаажуулсан.</p> <p>Шинжилгээгээр оролцож, үр чадвараа олон улсаар баталгаажуулсан.</p> <p>Түүнчлэн БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгын Засгийн газрын Төв лабораториос зохион байгуулсан "Ханз бичигт хийх шинжилгээ"-ний олон улсын сорилтод Бичиг баримтын шинжилгээний лаборатори хамрагдаж, шинжилгээний үр дүнг баталгаажуулсан.</p> <p>Үндэсний үр чадварын сорилтын хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс зохион байгуулсан "Иммуногематологийн шинжилгээний үндэсний чанарын гадаад үнэлгээ"-нд Биологийн шинжилгээний лаборатори цусны бүлэг тодорхойлох шинжилгээний чиглэлээр, "Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ"-аас зохион байгуулсан "CGL PT02 Хүдэр 2024" үр чадварын сорилтын 13-р тойрогт Физикийн шинжилгээний лаборатори тус тус амжилттай хамрагдсан.</p> <p>Улирлагын академикас зохион байгуулдаг Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 14, нийт 20 алба хаачийг хамруулан сургалтын гэрчилгээг авсан.</p> <p>БНСУ, АНУ, БНЭУ, Япон, ХБНГУ, БНХАУ, ОХУ, Тайланд, Казакстан зэрэг улсуудад зохион байгуулагдсан 27 эрдэм шинжилгээний хурал, олон улсын чуулга уулзалт, симпозиум, мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад давахардсан тоогоор нийт 130 алба хаагчийг хамруулсан.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/09 дүгээр тушаалаар Байгалийн ухааны шинжилгээний газарт "Митохондрийн ДНХ-ийн шинжилгээний лаборатори"-ийг шинээр байгуулж, хэргийн газраас хураан авсан махны дээжид митохондрийн гений дараалал тогтоох шинжилгээг хийж, Улаан номд орсон нэн ховор амьтан болох "Хандгай (Alicia alices)". Хулан адуу (Equus hemionus), Хүрэн баавгай (Ursus arctos) болохыг, улсын хилээр авч гарах гэж байсан үл мэдэгдэх соёоны дээжүүдэд митохондрийн "Cyb", "COI" гений дарааллыг тогтоох шинжилгээ хийж, Гэрийн тэмээ (Capreolus bactrianus) болохыг, шинжилгээнд ирүүлсэн махны дээжид амьтны ДНХ-ийн дараалал тогтоох шинжилгээ хийж хандгай, гэрийн ямаа, хар сүүлт болохыг тус тус тогтоож ажилласан.</p> <p>Дээрх шинжилгээнүүд нь Монгол Улсын Шүүх шинжилгээний практикт анх удаа хийгдсэн бөгөөд цаашид нэн ховор амьтан агнасан, тэдгээрийн эд эрхтний худалдаалаасан, хил давуулсан зэрэг гэмт хэрэгт бүх төрлийн амьтны цус, эд, эрхтний хэсгээс митохондрийн генийн түвшинд тухайн амьтны төрөл зүйлийг тогтоож, дүгнэлт гаргах бүрэн чадамжтай болсон.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/09 дүгээр тушаалаар Байгалийн ухааны шинжилгээний газарт "Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөлөх бодисын шинжилгээний лаборатори"-ийг шинээр байгуулж, НҮБ-ын 1961, 1971, 1988 оны конвенцын жагсаалтад ороогүй, Монгол Улсад өмнө нь бүртгэгдэж байгаагүй шинэ төрлийн мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөлөх 5 төрлийн бодис, бусад нэгдлүүдийг шинжилгээгээр тогтоож ажилласан.</p>						

